

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ЗАВСРЫН АУДИТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сайнцагаан сум

2018 оны 07 дугаар сарын 18

1. **Аудитын нэр:** Дундговь аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын 2018 оны санхүүгийн тайланд хийх завсрын аудит
2. **Үндэслэл:** Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 15.2.2 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/124 тоот “Төрийн аудитын байгууллагас санхүүгийн аудит хийх журам”-ын 9.1.2 дахь заалт, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв.
3. **Зорилго, зорилт:** Санхүүгийн тайлангийн завсрын аудитын зорилго нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл ажлын хүрээнд Дундговь аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайлан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ болон холбогдох хууль, заавар журмын дагуу үнэн, зөв бэлтгэгдсэн эсэхийг шалгах, аудитын төлөвлөлтийн үе шатны ажлын хүрээнд байгууллагын дотоод хяналтыг үнэлэх, эрсдэлийг тодорхойлж, үнэлэхэд чиглэгдэнэ. Мөн аудитын үеэр харилцагч байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудад заавар, зөвлөгөө өгөх, өмнөх аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад чиглэнэ.
4. **Аудитаар хийгдэх ажлууд:**
 1. Хөрөнгийн үлдэгдэлд газар дээр нь биет тест хэрэгжүүлэх, үндсэн хөрөнгө, бараа материалд хэсэгчилсэн хяналтын тооллого хийх, зарцуулалтад давтан тооцоолол хийх, хөрөнгийг данс бүртгэлд бүрэн, үнэн, зөв тусгасан эсэхийг тулган шалгах.
 2. Санхүүжилт, орлого, зардлын гүйлгээг түүвэрлэн хууль, заавар журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгах, ажил гүйлгээг тулган баталгаажуулах, дүнгээс хөөн шалгах, давтан тооцоолол хийх;
 3. Өглөг, авлагын гүйлгээг дэлгэрэнгүй журнал, ерөнхий дэвтэртэй тулган шалгах, харилцагч байгууллагаас лавлагаа авч үлдэгдлийг тулган баталгаажуулах;
 4. Өмнөх аудитаар тогтоосон акт, өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт, СХС-н зээлийн авлагын барагдуулалтын хэрэгжилтийг газар дээр нь тулган баталгаажуулах;

5. **Хамрах хүрээ, арга зүй:** Завсрын аудитад Дундговь аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл болон бусад холбогдох баримт материалыг бүрэн хамруулна.
6. **Шалгуур:** Завсрын аудит хийх зорилго, зорилттой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгоно. Үүнд:
1. Төсвийн байгууллагуудад мөрдөх санхүү болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, заавар журам, тогтоол, шийдвэрүүд / Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын баталсан журам, заавар, Дундговь аймгийн ИТХ-ын тогтоолууд, Засаг даргын захирамжууд ... гм /
 2. УСНББОУС, СТОУС, НББОУС
 3. Аудитын олон улсын стандарт
 4. Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын журам, гарын авлага
 5. Бусад
7. **Хугацаа:** Завсрын аудитыг 9 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэнэ.
8. **Ажлын хөтөлбөр, хуваарь:** Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөрийг Хавсралт №1, хуваарийг хавсралт №2, завсрын аудитаар гүйцэтгэх аудитын дэлгэрэнгүй горимыг хавсралт № 3-т тус тус харуулсан болно.
9. **Завсрын аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Завсрын аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер хянан удирдаж, Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор, аудитор нар батлагдсан хөтөлбөрийн дагуу тус тус гүйцэтгэнэ.

Төлөвлөгөө боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

Төлөвлөгөө хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Т.БАТСАЙХАН



Х.НАРАНЦАЦРАЛ